- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,207.4 сая төгрөг болж 311.2 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	274.0	301.8	27.8
Авлага	85.3	66.1	-19.2
Бараа материал	169.0	211.5	42.5
Үндсэн хөрөнгө	4,367.9	4,628.0	260.1
Нийт хөрөнгө	4,896.2	5,207.4	311.2
Өр төлбөр	43.5	173.5	130.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,852.7	5,055.5	202.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,896.2	5,229.0	332.8

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 490.6 сая төгрөг болж, өмнөх оноос 109.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	274.0	301.8	27.8
Төгрөг	274.0	301.8	27.8
Төрийн сангийн харилцах	274.0	301.8	27.8
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	274.0	301.8	27.8

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 301.8 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 85.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 90.9 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 125.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.4.2 Авлага

дансны эцсийн үлдэгдэл 66.1 сая төгрөг болж, өмнөх оноос 19.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	6.6	5.9	-0.7
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.3	0.3
Хувь хүмүүсээс авах авлага	22.8	22.8	0.0
Зээлийн авлага	55.9	37.1	-18.8
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Дүн	85.3	66.1	19.2

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлага дансны үлдэгдэл 66.1 сая төгрөг болж 19.2 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага буурсан нь голчлон нөлөөлжээ.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 211.8 сая төгрөг болж, өмнөх оноос 42.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	0.7	0.7	0
Аж ахуйн материал	85.4	133.9	48.5
Сэлбэг хэрэгсэл	22.8	22.8	0
Хүнсний материал	0.2	0.0	-0.2
Бусад хангамжийн материал	27.0	21.4	-5.6
Мал амьтад	32.8	32.8	0
Дүн	168.9	211.8	42.9

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь аж ахуйн бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,116.3 сая төгрөг болж, өмнөх оноос 36.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,724.60	3,064.20	339.6
Хуримтлагдсан элэгдэл	-446.8	-538.9	-92.1
Авто тээврийн хэрэгсэл	434.3	469.6	35.3
Хуримтлагдсан элэгдэл	-133.5	-183.1	-49.6
Машин тоног төхөөрөмж (компьютер)	230.4	238.9	8.5
Хуримтлагдсан элэгдэл	-120.3	-151.8	-31.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	120.2	164.5	44.3
Хуримтлагдсан элэгдэл	-50.8	-70.1	-19.3
Зам гүүрний барилга байгууламж	1,281.80	1,315.30	33.5
Хуримтлагдсан элэгдэл	-54	-121.9	-67.9
Бусад үндсэн хөрөнгө	345.9	475.9	130
Хуримтлагдсан элэгдэл	-101.6	-176.9	-75.3
Ном	0	0	0
Программ хангамж	1.5	6.5	5
Хуримтлагдсан элэгдэл	-1.5	-2.1	-0.6
Бусад биет бус хөрөнгө	137.8	137.8	0
Хуримтлагдсан элэгдэл			
Дүн	4,367.90	4,628.00	260.1

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,628.0 сая төгрөг болж 260.1 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламж болон зам гүүрний барилга байгууламж дансанд шинээр хөрөнгө нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 197.9 сая төгрөг болж, өмнөх оноос 106.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	37.7	143.9	106.2
Хувь хүмүүст төлөх өглөг	5.8	2.7	-3.1
Татварын өглөг	0	11.5	11.5
НДШ өглөг	0	0.2	0.2
Дүн	43.5	173.5	130.0

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 173.5 сая төгрөг болж 130.0 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг өссөнөөс шалтгаалжээ.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,033.8 сая төгрөг болж, өмнөх оноос 181.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	401.3	396.4	-4.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	4.9	4.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	4,293.8	4,475.0	176.3
Өмнөх үеийн үр дүн	4,181.7	4,293.8	112.1
Тайлант үеийн үр дүн	112.1	181.2	69.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157.6	157.6	0.0
Дүн	4,852.7	5,033.8	181.1

Эх сурвалж: Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 181.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.4.7 Орлогын данс

Сагил сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн сумын төсөв тодотгон батлах тухай 06/04 дугаар тогтоолоор Сагил сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 719.2 сая төгрөгийн орлого сумын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 670.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 93.2 хувиар биелүүлсэн байна.

3.4.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 17.4 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

- Сагил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нэг албан хаагчаас 0.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү тооцон суутгаж өглөгөөр бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт " Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн тул санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж залруулга хийлгэсэн.

Сагил сумын Засаг даргын тамгын газар:

- Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Сагил сумын Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2.0 сая, Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 5.0 сая нийт 7.0 сая төгрөгийг бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байсан тул албан шаардлага өгсөн.
- Тайлант онд Сагил сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8.8 сая төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй тул зөвлөмж өгсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг 2,471.7 сая төгрөгөөр тооцож санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 759.6 сая, төсвийн дэмжлэгээр 1,063.7 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 288.3 сая, урьд оны үлдэгдлээс 67.3 сая, үйл ажиллагааны орлогоос 70.0 сая, хоршоо хөгжүүлэх сангаас 93.2 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 60.2 сая, Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 5.0 сая, урьд оны үлдэгдлээс 64.4 сая санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сагил сумын 2025 оны төсвийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 3/08 дугаар тогтоолоор 2,471.7 сая төгрөгөөр баталж 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 6/04 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 292.9 сая төгрөгөөр бууруулж 2,178.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сагил сумын ИТХ-ын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 6/04 дугаар тогтоолоор 292.9 сая төгрөгөөр бууруулан төсөвт тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,586.9 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 203.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 47.3 сая нийт 1,837.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,809.8 сая төгрөгийг зарцуулж, 13.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,809.8 сая төгрөг буюу 83.1 хувьтай байгаа нь зардлыг 13.1 сая төгрөгөөр хэмнэж, гүйцэтгэлээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдож 301.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,292.3 сая төгрөг буюу 83.5 хувьтай байна.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн:

Хүснэгт 8.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл		Нийт дүн
		Сагил ИТХ	Сагил ЗДТГ	
1	Программ хангамжийн бүртгэл	2.0	3.0	5.0
2	Унаа, хоолны зардал	0.0	0.0	0.0
3	Сургалт, семинар	0.0	3.5	3.5
4	Гадаад томиллолт, арга хэмжээ	0.0	0.0	0.0
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	0.0
6	Хэвлэл мэдээлэл	0.0	0.0	0.0
7	Орон тоо	3	29	32

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 311.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.3 сая, ЗГНХ, ЗДНХ хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 60.0 сая нийт 373.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 303.5 сая төгрөгийг зарцуулж 70.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагил сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2025 онд харьцуулалтын аргаар 4, шууд худалдан авалт 7, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар нээлттэй тендер шалгаруулалт 1 нийт 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

ТШ код	Тендер шалгаруулалтын нэр	ТШ төрөл	Төсөвт өртөг	Тухайн оны санхүүжих өртөг	ХАА-д мөрдөх журам	Тендер зарлах огноо
УВАССЗДТГ/2 0250602019	Өвс авах	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	11/5/2025
УВАССЗДТГ/2 0250303007	Золбин нохой устгах	Үйлчилгээ	3,000,000 ₮	3,000,000 ₮	Шууд худалдан авалт	4/1/2025
УВАССЗДТГ/2 0250601023	Наадмын талбайн дутуу санхүүжилт	Ажил	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	11/5/2025
УВАССЗДТГ/2 0250301005	Сумын төвийн камержуулалт	Ажил	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	4/1/2025
УВАССЗДТГ/2 0250201001	Улаан байрны засвар	Ажил	150,000,000 ₮	150,000,000 ₮	Харьцуулалтын арга	4/1/2025
УВАССЗДТГ/2 0250302013	Баянзүрх багийн худагт мотор авах	Бараа	5,000,000 ₮	5,000,000 ₮	Шууд худалдан авалт	9/1/2025
УВАССЗДТГ/2 0250202003	Соёлын төвийн техник хэрэгсэл	Бараа	40,000,000 ₮	40,000,000 ₮	Харьцуулалтын арга	5/1/2025
УВАССЗДТГ/2 0250101017	Наадмын талбайн засвар, тохижилтын ажил	Ажил	200,000,000 ₮	200,000,000 ₮	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	4/25/2025
УВАССЗДТГ/2 0250601018	Өндөрмод багийн төвийн тохижилт, засвар	Ажил	6,571,800 ₮	6,571,800 ₮	Шууд худалдан авалт	11/5/2025
УВАССЗДТГ/2 0250602020	бэдтэй ногоон пресс	Бараа	20,000,000 ₮	20,000,000 ₮	Шууд худалдан авалт	12/10/2025
УВАССЗДТГ/2 0250202021	хорголжин тэжээл	Бараа	59,096,000 ₮	59,096,000 ₮	Харьцуулалтын арга	12/10/2025
УВАССЗДТГ/2 0250202022	Тэжээл	Бараа	60,000,000 ₮	60,000,000 ₮	Харьцуулалтын арга	11/5/2025

Тайлант онд огт хэрэгжээгүй 3 төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарлагын гүйлгээг хязгаарласантай холбоотой санхүүжилт дутуу олгосон 2 төсөл арга хэмжээ байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,395.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 23.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,474.5 сая төгрөгийн 1 хувиар буюу 24.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 19.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 186.8 сая төгрөгийн 2 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146.5 сая төгрөгийн 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 56.8 сая төгрөгийн 2 шийдвэр, Байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тус тус байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд :

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж сумын Засаг даргын 2025 оны А/99 дүгээр захирамжаар сумын ОНХС-аас 60.0 сая төгрөгийг сумын засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгснийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 1/39 дугаар албан бичгээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын fas.audit.mn цахим системд байршуулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сагил сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар баталсан ч сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар тамгын газрын бүтэц, орон тоо, цалин нэмэгдлийг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй селесерь, хөдөөгийн 5 багийн сахиулыг гэрээтээр цалинжуулан ажиллаж байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 төсвийн байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгч, 1 төсвийн байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 17.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.1 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 8.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 8.5 сая төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 9.

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	3	17.3					2	8.5	1	8.8
2	ИТХ	1	0.1	1	0.1						
		4	17.4	1	0.1			2	8.5	1	8.8

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 450.1 сая төгрөгийн нийцлийн аудитын асуудлын зөрчил илэрснээс 390.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 60.0 сая төгрөгийн 1 зөрчил зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 186.8 сая төгрөгийн 2 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146.5 сая төгрөгийн 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 56.8 сая төгрөгийн 2 шийдвэр, Байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 дахь заалтад "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1 дэх заалтад "Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.3 дахь заалтад "Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь заалтад "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр сумын Засаг даргын 2025 оны А/99 дүгээр захирамжаар сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 60.0 сая төгрөгийг сумын засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг хэрэгжүүлэн хэрэгжүүлж ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сагил сум	1	390.1			1	390.1		
Дүн	1	390.1			1	390.1		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сагил сум	1	60.0					1	60.0
Дүн	1	450.1					1	60.0
Нийт дүн	1	450.1			1	390.1	1	60.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

Т.АМАРМЭНД/

2026 оны 03 сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 01/55/А.2026/13
УВА-2026/0101/НА-СГА-ТТЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан талбарт 186.8 сая төгрөгийн 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146.5 сая төгрөгийн 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 56.8 сая төгрөгийн 2 шийдвэр, байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1 дэх заалтад “Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4.3 дахь заалтад “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “Хууль, тогтоомж,

гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сагил сумын Засаг дарга Г.Чинзориг, Санхүү албаны дарга Ч.Раднаасамбуу, Нягтлан бодогч З.Бат-Оргил нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.АМАРМЭНД

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ